

## **БАРАА, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ТҮР ХУГАЦААГААР НЭВТРҮҮЛЭХ АТА КАРНЕЙ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Бараа, тээврийн хэрэгслийг Монгол улсын нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах олон улсын гаалийн баримт АТА карнейг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн хууль тогтоомж, Бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар нэвтрүүлэх тухай 1990 оны Станбулын конвенци болон энэ журмыг баримтална.

1.2. Гадаад бараа, тээврийн хэрэгслийг өөрчлөлт оруулахгүйгээр хугацаанд нь буцаан гаргах нөхцөлтэйгөөр, дотоодын бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар өөрчлөлт оруулахгүй тогтоосон хугацаанд буцаан оруулах үндэсний гаалийн мэдүүлгийг орлох АТА карнейг бүрдүүлэх, хураан авах, татвар хураамж төлөх нөхцөл, хүчинтэй хугацаа дуусгавар болохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3. АТА карнейг ашиглах нь сайн дурын байх бөгөөд хүчинтэй АТА карнейг Монгол Улсын хуулийн дагуу тогтоосон гаалийн байгууллагууд хүлээн зөвшөөрч бараа тээврийн хэрэгслийг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулж, Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаргана.

1.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт орсон гарсан АТА карнейн нэгдсэн бүртгэлийг гаалийн байгууллага хийнэ.

1.5. Гаалийн тухай хуулийн Бараага гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горим хэрэгжүүлэх журам энэ журамд хамаарахгүй.

### **Хоёр. Монгол улсын нутаг дэвсгэрт үйлчлэх хүрээ**

2.1. Монгол улсын нутаг дэвсгэрт АТА карнейн үйлчлэх хүрээнд "Бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар нэвтрүүлэх тухай" 1990 оны Стамбулын Конвенцийн дор дурдсан хавсралтуудад заасан бараа бүтээгдэхүүн гаалийн татвар, хураамжаас тодорхой нөхцөлтэйгээр бүрэн чөлөөлөгдөн хамрагдана:

2.1.1. Хавсралт В1 - үзэсгэлэн яармаг, хурал болон бусад ижил төстэй арга хэмжээнд хэрэглэх бараа бүтээгдэхүүн

2.1.2. Хавсралт В2 - мэргэжлийн тоног төхөөрөмж

2.1.3. Хавсралт В5 - Сургалт, шинжлэх ухаан болон соёлын зориулалтаар оруулж буй бараа бүтээгдэхүүн

2.1.4. Хавсралт В3 - арилжааны үйл ажиллагаатай холбогдуулан оруулсан чингэлэг, тавиур, баглаа боодол, дээж болон бусад барааны тухай

2.1.5. Хавсралт С - тээврийн хэрэгслийн тухай

2.2. АТА карней нь олгогдсон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

2.3. МҮХАҮТанхим нь Олон улсын баталгааны сүлжээнд нэгдэн орсон баталгаа гаргагч байгууллага бөгөөд АТА карнейн эзэмшигчийн зүгээс Монгол Улсын хууль болон Стамбулын конвенцид заасан нөхцлүүдийг зөрчсөн тохиолдолд Монгол Улсын гаалийн байгууллага гаалийн болон бусад татвар, торгуулийг Станбулын Конвенцид заасан хугацааны дотор нэхэмжлэн нөхөн төлүүлнэ.

### **Гурав. Монгол улсаас гадаадын улс оронд АТА карнейг авч гарах нөхцлүүд**

- 3.1. Монгол улсын нутаг дэвсгэрт АТА карнейг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим олгох, бүрдүүлэлт хийх, хяналт тавих үүрэгтэй.
- 3.2. Танхим нь өөрийн хяналтанд АТА карнейг бүрдүүлэх, олгох, хяналт тавих зөвшөөрлийг өөрийн салбар Танхимуудад олгох эрхтэй.
- 3.3. Гадаадын улс оронд түр хугацаагаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхэд гарах хязгаарлалтуудын талаархи мэдээллийг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас авна.
- 3.4. Түр хугацаагаар нэвтрүүлсэн бараа, тээврийн хэрэгслийг тухайн улсаас буцааж гаргах буюу ре-экспортлох үед тухайн бараа бүтээгдэхүүнд ямарваа нэг өөрчлөлт оруулсан, зарж борлуулсан байхыг хатуу хориглоно.
- 3.5. Түр хугацаагаар бараа, тээврийн хэрэгслийг авч зорчих улсын тоо нэг жилийн дотор 10-аас хэтрэхгүй байна.
- 3.6. АТА карнейг олгосноос хойш карней эзэмшигч болон гаалийн байгууллага ямар ч тохиолдолд барааны ерөнхий жагсаалтад өөрчлөлт, засвар оруулах эрхгүй. Карнейн хүчинтэй хугацаа дуусах өдөр хүртэл ерөнхий жагсаалтанд орсон бараа тус бүрийн дугаарыг өөрчлөхгүй.

### **Дөрөв. Монгол Улсын нутаг дэвсгэрт АТА карней дагалдуулсан бараа бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэл оруулах нөхцлүүд**

- 4.1. Олгосон улсад АТА карнейн бүрдүүлэлт хийгдэн Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирсэний дараа түүнд орсон мэдээллийг засаж, өөрчлөхийг хатуу хориглоно. Аль ч улсын Гаалийн байцаагч болон АТА карней эзэмшигч өөрөө дур мэдэн өөрчлөлт оруулах эрхгүй.
- 4.2. АТА карнейг англи хэлээр бөглөнө. Англи хэлээс өөр хэл дээр бөглөсөн байх тохиолдолд гаалийн байгууллага тухайн улсын хэл эсвэл англи хэл дээр орчуулгыг шаардах эрхтэй.
- 4.3. АТА карнейг дагалдах бараа, тээврийн хэрэгслийг худалдан борлуулахыг хатуу хориглоно.
- 4.4. АТА карнейг дагалдах бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулсан тухайн улсын гаалийн байгууллагын тогтоосон хугацаанд тус улсын нутаг дэвсгэрээс буцаан гаргана. Гаргаагүй нөхцөлд тухайн орны гаалийн хууль дүрэм, журмын дагуу импортын гаалийн татвар ногдуулахаас гадна хугацаа хэтэрсний торгуулийг давхар ногдуулна.
- 4.5. АТА карнейг дагалдсан бараа, тээврийн хэрэгслийг тухайн улсын нутаг дэвсгэрээс буцаан гаргаагүй, хулгайд алдсан, устгасан тохиолдолд тэдгээрт импортын гаалийн татвар ногдуулна. Хулгайд алдсан тохиолдолд нэн даруй тухайн орны цагдаагийн байгууллага, гаалиас тодорхойлолт авсан байх шаардлагатай.
- 4.6. АТА карнейн маягтын эхний болон сүүлийн ногоон өнгийн хуудасгүйгээр тус АТА карней хүчингүйд тооцогдоно.
- 4.7. Энэхүү журмаар зохицуулаагүй асуудлыг Станбулын Конвенци болон

холбогдох хууль тогтоомжоор шийдвэрлэнэ.

### **АТА карнейн загвар**

Эхний ногоон хуудас буюу хавтас /Green cover page/. Үүнд,

А нүд - карней эзэмшигч; Карнейд заасан бараа бүтээгдэхүүнийг эзэмшигчийн овог нэр, албан ёсны хаяг

В нүд - Төлөөлөгч; Гааль дээр төлөөлөн бараа бүтээгдэхүүнээ хяналт шалгалтанд оруулах хүний нэр

С нүд - Бараа бүтээгдэхүүнийг гаргах зорилго; Үзэсгэлэн яармаг, мэргэжлийн тоног төхөөрөмж, худалдааны загвар, соёл урлагийн арга хэмжээ гэх мэт.

Г с) нүд - АТА карнейн хүчинтэй хугацаа

Р нүд - АТА карнейг ашиглах боломжтой улс орнуудын жагсаалт

Н нүд - АТА карнейг гаргаж байгаа улсын гаалийн байгууллагын баталгаажуулалт. Үүнд,

Н а) нүд - Ерөнхий жагсаалтын орсон бараа бүтээгдэхүүн тус бүрийн харалдаа 7 дугаар баганад тавигдсан таних тэмдэглэгээг хийв. /Энэхүү хэсэгт Ерөнхий жагсаалтад орсон бараа бүтээгдэхүүнийг таних тэмдэглэгээ хийснийг баталж тоо ширхэгийг тавина /1-20 тоо ширхэг бараа бүтээгдэхүүн орсон гэх мэтээр/

Н б) нүд - Бараа бүтээгдэхүүнийг шалгасан эсэх. Тийм Үгүй гэсэн нүхэнд тэмдэглэх

Н с) нүд - Бүртгэлийн дугаар. Тухайн гаалийн байгууллагаас тавигдах тухайн АТА карнейн бүртгэлийн дугаарыг тавих

Н d) нүд - тухайн гаалийн байгууллагын нэр, газар, огноо, байцаагчийн гарын үсэг, тамга

І нүд - АТА карнейг олгосон этгээдийн гарын үсэг, байгууллагын тамга, нэр, огноо

Ј нүд - АТА карней эзэмшигчийн гарын үсэг

Эхний хуудасны эсрэг тал буюу Ерөнхий жагсаалт /General list:/:

1 багана - Бараа бүтээгдэхүүний дэс дугаар: Нийт барааны тоо ширхэг дэс дугаартай тохирох ёстой

2 багана - Барааны тодорхойлолт: Бараа бүтээгдэхүүний марк, модель, хэлбэр, серийн дугаар болон барааг тодорхойлоход шаардлагатай бүх мэдээллийг маш тодорхой, ойлгомжтой дурьдах мөн сав баглаа боодлын мэдээллийг оруулах

3 багана - Тоо ширхэг: барааны тоо ширхэг,

4 багана - Жин: барааны цэвэр, бохир жин, сав баглаа боодлын объемыг заах

5 багана - Үнэ: Татвар, НӨАТ нэмэгдээгүй үнэ тус бүрийг америк доллараар бичих

6 багана - Бараа бүтээгдэхүүний гарал үүсэл: /улсаар ISO кодын дагуу нэрлэх/

7 багана - Гаалийн байгууллагын хэрэгцээнд: Шаардлагатай тэмдэглэгээг гаалийн байгууллага хийнэ

Хүснэгтийн доод талд нийт хэмжээг тавина.

### **Шар өнгийн Экспортын болон ре-импортын тасалбар /Exportation & Reimportation counterfoil/**

Тус хуудсыг зөвхөн гаалийн байгууллагууд бөглөх бөгөөд ар өвөргүй 4 удаагийн аялалд ашиглагдах экспортын болон ре-импортын хувиуд байгааг анхаарна уу. Нэг удаагийн аялалд зөвхөн эхний хосыг ашиглана. Тухайн бараа бүтээгдэхүүн анх гарч байгаа улсын гаалийн байгууллага Экспортын тасалбарыг бөглөнө. /Exportation counterfoil/. Үүнд,

1. Ерөнхий жагсаалтанд ..... дугаарын дор тодорхойлогдсон бараа бүтээгдэхүүн экспортод гарсан. Хоосон зайд тэдээс тэд дугаарын бараа гарсан гэсэн тэмдэглэгээг хийнэ. Тоогоор бичиж болно. 1-25 гэх мэт

2. Татвараас чөлөөлөгдөн буцаан оруулах эцсийн хугацаа: он, сар, өдөр. Үүнд, Тухайн бараа бүтээгдэхүүнийг буцаан оруулах хугацааг гаалийн байгууллагаас тогтоосон тохиолдолд тэмдэглэх.

3. Бусад тэмдэглэгээ.

4. Тухайн гаалийн байгууллагын нэр

5. Газар

6. Огноо

7. Тухайн байцаагчийн гарын үсэг, тамга тэмдэг

Экспортын маягтын дор байгаа ре-импортын тасалбарыг /Reimportation counterfoil/ тухайн бараа бүтээгдэхүүн буцаж орж ирэх үед бөглөнө. Үүнд,

1. Ерөнхий жагсаалтанд ..... дугаарын дор тодорхойлогдсон, энэхүү карнейн .... дугаарын экспортын тасалбарын дагуу түр хугацаагаар экспортод гарсан бараа бүтээгдэхүүн буцаж оров.

2. Бусад тэмдэглэгээ

3. Гаалийн байгууллагын нэр

4. Газар

5. Огноо

6. Гарын үсэг, тамга

### **Цагаан өнгийн Импортын болон ре-экспортын тасалбар маягтууд Importation & Reexportation counterfoil**

Мөн экспортыш болон ре-импортыш тасалбар маягтуудын адил 4 удаагийн аялалд зориулагдсан бөгөөд зөвхөн гаалийн байгууллагууд бөглөнө.

Импортын тасалбар хуудсанд дараах зүйлсийг тэмдэглэнэ. Үүнд,

1. Ерөнхий жагсаалтын .... дугаарт тодорхойлогдсон бараа бүтээгдэхүүн түр хугацаагаар импортлогдсон. Хоосон зайд жагсаалтад орсон бараа бүтээгдэхүүний дугаарыг тавина.

2. Буцаан гаргах эцсийн хугацаа. Тухайн гаалийн байгууллагын шийдвэрийн дагуу шаардлагатай бол тавигдана.

3. Бүртгэлийн дугаар

4. Бусад тэмдэглэгээ

5. Гаалийн байгууллагын нэр
6. Газар
7. Огноо
8. Байцаагчийн гарын үсэг, тамга

Ре-экспортын тасалбар хуудас /re-exportation counterfoil/

1. Ерөнхий жагсаалтанд тодорхойлогдсон, энэхүү карнейн .... дугаарын импортын нотолгоо хуудсын дагуу түр хугацаагаар импортоор оруулсан бараа бүтээгдэхүүн ре-экспортоор гарсан.
2. Гаалид мэдүүлсэн боловч буцаан гаргаагүй бараа бүтээгдэхүүнд авсан арга хэмжээ.
3. Гаалид мэдүүлээгүй бөгөөд ре-экспортоор гаргахгүй тохиолдолд авсан арга хэмжээ.
4. Бүртгэлийн дугаар
5. Гаалийн байгууллагын нэр
6. Газар
7. Огноо
8. Байцаагчийн гарын үсэг, тамга

Экспортын ваучерыг /Exportation voucher/ бараа бүтээгдэхүүнийг анх гаргаж байгаа улсын гаалийн байгууллага дээр шаардлагатай тэмдэглэгээ хийлгэх бөгөөд тухайн гааль дээр баримт болон үлдэнэ.

- A. Карнейн эзэмшигчийн нэр болон хаяг
- B. Төлөөлж буй этгээдийн нэр
- C. Бараа бүтээгдэхүүнийг гаргах зорилго
- D. Тээврийн хэрэгсэл
- E. Сав баглаа боодлын тодорхойлолт /тоо, төрөл, хаяг, шошго гэх мэт/
- F. Түр хугацааны экспортын мэдүүлэг /Энэ хэсгийг АТА карней эзэмшигч бөглөж, гарын үсгээ зурсан байна/. Үүнд,

Миний бие бүрэн эрхийхээ хүрээнд:

- a) Энэхүү хуудасны эсрэг талд дугаарлуулан Ерөнхий жагсаалтанд ..... оруулсан бараа бүтээгдэхүүнийг түр хугацаагаар экспортод гаргаж буйгаа үүгээр мэдэгдэж b) Эдгээр бараа бүтээгдэхүүнийг Гаалийн байгууллагын тогтоосон хугацаанд буцаан гаргаж, тэдгээрийн статусыг импортлогч улс/гаалийн нутаг дэвсгэрийн хууль, тогтоомж журмын дагуу зохицуулахаа үүгээр хүлээж c) Дээрх мэдээлэл үнэн зөв гэдгийг үүгээр баталж байна.

Газар....

Огноо ...

Нэр ....

Гарын үсэг ...

Гаалийн байгууллагын хэрэгцээнд гэсэн нүдэнд тухайн гаалийн байгууллага дараах мэдээллийг оруулна. Үүнд, Н. Экспортын бүрдүүлэлт

- a) Дээрх мэдүүлэгт тодорхойлсон бараа бүтээгдэхүүн түр

хугацаагаарэкспортод гарсан болохыг тодорхойлов.

- b) Татавараас чөлөөлсөн ре-импорт хийх эцсийн хугацаа он, сар, өдөр
- c) Энэхүү ваучер нь Гаалийн байгуулагад үлдэх ёстой.
- d) Бусад тэмдгэлгээ

Гаалийн байгууллагын нэр....

Огноо

Гарын үсэг, тамга

---oO---